



МОНГОЛ УЛСЫН  
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 343

Улаанбаатар хот

Аргачлал шинэчлэн батлах тухай

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аж ахуйн нэгж, байгууллагын “Санхүүгийн тайланд шинжилгээ хийх үлгэрчилсэн аргачлал”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

Хоёр. Энэ тушаалын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Х.Пүрэвсүрэн/-т даалгасугай.

Гурав. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Сангийн сайдын 2013 оны 277 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Б.БОЛОР

090782

Сангийн сайдын 2015 оны 12 дугаар  
сарын 18-ны өдрийн 342 тоот  
тушаалын хавсралт

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНД ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ҮЛГЭРЧИЛСЭН  
АРГАЧЛАЛ

НЭГ . Нийтлэг зүйл

1. Энэхүү аргачлалын зорилго нь аж ахуйн нэгж, байгууллагуудад санхүүгийн тайлангийн шинжилгээ хийх нэгдсэн үзүүлэлт болон арга зүйг нэг мөр болгон туслалцаа үзүүлэх,
2. Аж ахуйн нэгж, байгууллагын санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүдийг харьцуулах боломжийг хангахад оршино.
3. Санхүүгийн тайлангийн шинжилгээний зорилго нь.
  - а. Аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд санхүү эдийн засгийн хувьд дэвшүүлсэн зорилт, түүний биелэлтийг тодорхойлох.
  - б. Санхүү, эдийн засгийн өнөөгийн хүрсэн түвшин, ирээдүйн хандлагыг тодорхойлох.
  - в. Санхүүгийн бодлого, ирээдүйн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүжилтийн бололцоог үнэлэн тодорхойлж, удирдлагын оновчтой шийдвэр гаргахад туслах зэрэг болно.
4. Аж ахуйн нэгж, байгууллагууд улирал, жилийн санхүүгийн тайлангийн шинжилгээ хийхдээ энэхүү үлгэрчилсэн аргачлалыг үндэс болгохын хамт үзүүлэлтүүдийг өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан өөрчлөн хэрэглэж болно.

ХОЁР. Санхүүгийн тайлангийн шинжилгээ

1. Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд шинжилгээ хийх мэдээллийн бааз нь
  - 1.1. Тайлант болон өнгөрсөн мөн үеийн санхүүгийн тайлан
  - 1.2. Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулга
  - 1.3. Байгууллагын бизнес төлөвлөгөө, орлого зарлагын төсөв, эдийн засгийн бусад төлөвлөгөөт болон нормативт үзүүлэлт
  - 1.4. Удирдлагын шийдвэр, гэрээ хэлэлцээ
  - 1.5. Бусад тооцоо судалгаа зэрэг болно
2. Санхүүгийн тайлангийн шинжилгээний ажлын дэс дараалал, хамрах хүрээ
  - 2.1. Тухайн шинжилгээний зорилго, хамрах хүрээ, хугацааг тодорхойлох
  - 2.2. Урьдчилсан тойм гаргах
    - 2.2.1. Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны чиглэл, онцлогыг тодорхойлох
    - 2.2.2. Санхүүгийн тайлан түүний тайлбар, тодруулгыг уншиж ололт дутагдлыг урьдчилан тоймлох
    - 2.2.3. Санхүүгийн хүндрэлд орж болзошгүй байдлыг урьдчилан тооцох
  - 2.3. Санхүүгийн гүйцэтгэлийг үнэлж дүгнэх
    - 2.3.1. Хөрөнгийн байдлыг үнэлэх
    - 2.3.2. Санхүү, төлбөрийн чадварыг үнэлэх
    - 2.3.3. Хөрөнгийн ашиглалтыг үнэлэх
    - 2.3.4. Ашиг, ашигт ажиллагааны үзүүлэлтүүдийг үнэлэх

- 2.3.5. Эдийн засгийн тогтворжилт, өсөлт хөгжлийн хандлага динамикийг тодорхойлох
- 2.3.6. Хөрөнгө оруулалтын томоохон шийдвэрүүдийг үнэлэх
- 2.3.7. Бизнесийн үйл ажиллагааг бүхэлд нь иж бүрэн үнэлэх
- 2.3.8. Санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд нэгдсэн дүгнэлт өгөх

3. Аж ахуйн нэгж, байгууллага улирал жилийн санхүүгийн тайланг үндэслэн санхүүгийн шинжилгээг хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд богино хугацааны шуурхай болон сэдэвчилсэн шинжилгээг нөлөөлсөн хүчин зүйлээр нь гүнзгийрүүлэн хийж болно.

### ГУРАВ. Санхүүгийн тайлангийн шинжилгээний үзүүлэлтүүдийг тооцох аргачлал

#### 3.1 Хөрөнгийн бүрэлдэхүүн, динамикийн шинжилгээ

Санхүүгийн байдлын тайлангийн үндсэн бүлэг, зүйл ангиудын бүрэлдэхүүн (хувийн жин), динамик (абсолют ба харьцангуй өөрчлөлт)-ийг тайлант үеийн эцэс болон эхний үлдэгдлээр зэрэгцүүлэн тодорхойлж үндсэн өөрчлөлтийн эерэг ба сөрөг нөлөө, үүссэн шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлээр нь дүгнэлт өгнө. Ингэхдээ бүтэц бүрэлдэхүүний өөрчлөлтийг тайлангийн хугацаанд дэвшүүлсэн зорилт, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, санхүүгийн бодлого, тэдгээрийн үр дүнтэй холбон тайлбарлах, дүгнэлт өгөх нь зүйтэй.

Компанийн санхүүгийн тайланд байгаа хөрөнгө, түүний эх үүсвэрийн бодит хэмжээ, бүтэц бүрэлдэхүүнийг тодорхойлж үнэлэлт, дүгнэлт өгөхөд ерөнхий шинжилгээний зорилго оршино.

Санхүүгийн тайлангийн шинжилгээний эхний алхам нь:

- Вертикал (босоо) шинжилгээ
- Горзонтал (хэвтээ) шинжилгээ

Байгууллагын мэдэлд ашиглагдаж байгаа хөрөнгө, эх үүсвэрийн бүрэлдэхүүн хэрхэн өөрчлөгдсөн, дотоод бүрэлдэхүүн хэсгүүдийн хувь хэмжээ зохистой түвшинд байгаа эсэхийг мэдэхийн тулд санхүүгийн байдлын тайлангийн цэвэр дүнд бүлэг зүйл тус бүрийн эзлэх хувийн жинг цаг хугацааны эхэн ба эцсийн байдлаар зэрэгцүүлж тооцохыг вертикал буюу босоо шинжилгээ гэнэ. Аливаа үзүүлэлтийн орон зайн болон цаг хугацааны хэлбэлзлийг үнийн дүн ба хувиар тодорхойлж дүгнэлт өгөх шинжилгээний арга зүйг горизонтал буюу хэвтээ шинжилгээ гэнэ.

Хөрөнгийг хөрвөх чадвараар нь

- Эргэлтийн хөрөнгө
- Эргэлтийн бус хөрөнгө

Дотоод ашиглагдаж байгаа эсэхээр нь

- Дотоод эргэлтэнд байгаа хөрөнгө
- Дотоод эргэлтээс гаргагдсан хөрөнгө /авлага, үнэт цаас, банкны хадгаламж, барьцаанд тавигдсан хөрөнгө/

Хөрөнгийн эх үүсвэрийг өмчлөл ба эзэмшигчийнх нь хувьд

- Өөрийн эх үүсвэр
- Гадны эх үүсвэр /Богино хугацаат өр төлбөр+Урт хугацаат өр төлбөр/

Тогтвортой ашиглагдах байдлаар нь

- Түр хугацаанд ашиглагдах эх үүсвэр/ Богино хугацаат өр төлбөр /
- Байнгын эх үүсвэр / Урт хугацаат өр төлбөр +Өөрийн эх үүсвэр/

Хөрөнгө капиталын бүрэлдэхүүн, хэлбэлзэл өөрчлөлтийг үнэлж дүгнэхдээ тоон талаас нь бус чанарын ахиц өөрчлөлт байгаа эсэхийг гол болговол зохино. Тухайлбал:

- Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай хөрөнгүүд буюу идэвхитэй хэсгийн хувийн жин, өсөлтийн давамгайлах байдал
- Түргэн хөрвөх хөрөнгийн хувь хэмжээ
- Сул чөлөөтэй хөрөнгийг оновчтой байршуулж үр өгөөжтэй ашиглаж байгаа байдал гэх мэт

Хөрөнгө, эх үүсвэрийн зэрэгцүүлсэн тайланг гаргаж санхүүжилтийн бодлогоо тодорхойлдог. Цэвэр эргэлтийн хөрөнгө нь өөрийн хөрөнгөөр санхүүжигдсэн эргэлтийн хөрөнгийн хэмжээг илэрхийлнэ.

- Цэвэр эргэлтийн хөрөнгө=Эргэлтийн хөрөнг-Богино хугацаат өр төлбөр

Өөрийн эргэлтийн капитал нь эргэлтийн хөрөнгийн санхүүжүүлэхэд оруулсан өөрийн хөрөнгийн хэмжээ юм.

- Өөрийн эргэлтийн капитал=Байнгын капитал-Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалт

Матриц хэлбэрийн зэрэгцүүлсэн тайлан

Актив \ Пассив	Богино хугацаат өр төлбөр	Урт хугацаат өр төлбөр	Эзний өмч	Өр төлбөр ба эзний өмчийн дүн
Эргэлтийн хөрөнгийн хувьсах хэсэг:				
Мөнгөн хөрөнгө				
Авлага				
Бараа материал				
Эргэлтийн хөрөнгийн тогтмол хэсэг				
Эргэлтийн хөрөнгө бус				
Нийт хөрөнгө				

### 3.2 Төлбөрийн чадварын шинжилгээ

Төлбөрийн чадвар гэдэг нь бусдын өмнө хүлээсэн санхүүгийн хариуцлага юм. Төлбөрийн чадварыг хүлээгдэж буй хугацааны богино үечлэлээр /хагас жил, улирал, сараар гэх мэт/ төлбөрийн төлөвлөсөн санхүүгийн тайланг урьдчилан тооцоолж үнэлэхээс гадна төлбөрийн хэрэгсэл болон өр төлбөрийн харьцаагаар төлбөрийн чадварыг тодорхойлно.

#### 3.2.1. Төлбөрийн хэрэгсэл болон өр төлбөрийн харьцаа:

##### а) Төлбөрийн хэрэгсэл:

Төлбөрийн хэрэгслийг хөрвөх чадвараар нь:

- А1-Шууд хөрвөх хөрөнгө /мөнгө, үнэт цаас/
- А2-Түргэн цуглуулах хөрөнгө /авлага, бусад тооцоо/
- А3-Удаан борлогдох хөрөнгө /бараа материал нөөц, зардал/
- А4-Борлогдоход хэцүү хөрөнгө /эргэлтийн бус хөрөнгө/

##### б) Өр төлбөр:

Өр төлбөрийг нэхэмжлэгдэх байдлаар нь:

- П1-Яаравчлагдсан өр /3 сарын дотор төлөх/
- П2-Богино хугацаатай зээл, төлбөр
- П3-Урт хугацаат зээл, төлбөр
- П4-Өөрийн капитал

Төлбөрийн чадварын нөхцөлүүд

1.Төлбөрийн үнэмлэхүй чадвартай	$A1 \geq П1, A2 \geq П2, A3 \geq П3, A4 \geq П4,$
2.Төлбөрийн чадвар хэвийн	$A1 \leq П1, A2 \leq П2, A3 \geq П3, A4 \leq П4,$
3.Төлбөрийн чадвар хангалтгүй	$A1 < П1, A2 < П2, A3 \geq П3, A4 \leq П4,$
4.Төлбөрийн чадвар муудсан	$A1 < П1, A2 < П2, A3 < П3, A4 \leq П4,$

Төлбөрийн чадварыг илэрхийлэгч үзүүлэлтүүдийн байвал зохих онолын утгыг дараах 3 түвшинд хувааж үзнэ. Үүнд:

Үзүүлэлтүүд	А түвшин	Б түвшин	В түвшин
Эргэлтийн харьцаа	>2.0	1.0-2.0	<1.0
Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа	>0.8	0.4-0.8	<0.4
Үнэмлэхүй хөрвөх хөрөнгийн харьцаа	>0.2	0.1-0.2	<0.1

#### 3.2.2. Төлбөрийн чадварын хэтийн боломжийг дараах үзүүлэлтүүдээр үнэлж дүгнэнэ. Үүнд:

$$а) \text{ Хүүтэй зээл төлбөрийн хувь хэмжээ} = \frac{\text{Банкны зээл} + \text{Өрийн бичгийн өглөг}}{\text{Гадны капитал}}$$

$$б) \text{ Хүүгийн дундаж хувь} = \frac{\text{Тайлангийн хугацаанд төлөхөөр тооцсон хүү}}{\text{Гадны капиталын дундаж үлдэгдэл}}$$

$$в) \text{ Хүү төлөх чадвар} = \frac{\text{Татварын өмнөх цэвэр ашиг} + \text{Хүүгийн зардал}}{\text{Хүүгийн зардал}}$$

$$г) \text{ Хүү ба үндсэн өрийг төлөх чадвар} = \frac{\text{ХТӨА} + \text{Байгуулсан элэгдэл}}{\text{ХЗ} + \text{Тухайн жилд төлөгдөх өрийн дүн}}$$

д) Цэвэр эргэлтийн хөрөнгө = Нийт эргэлтийн хөрөнгө - Богино хугацаат өр төлбөр

$$е) \text{ Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа} = \frac{\text{Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө} + \text{Санхүүгийн хөрөнгө} + \text{Дансны авлага}}{\text{Богино хугацаат өр төлбөр}}$$

Түргэн хөрвөх хөрөнгө = МТАХ + Санхүүгийн хөрөнгө + Дансны авлага  
Түргэн хөрвөх хөрөнгөнд бараа материал үнэ бүхий зүйлийг оруулдаггүй. Учир нь:

- Хөрвөх чадвар удаан
- Өртөгөөрөө төлбөрийн хэрэгсэл болж чаддаггүй

$$ё) \text{ Эргэлтийн харьцаа} = \frac{\text{Нийт эргэлтийн хөрөнгө}}{\text{Богино хугацаат өр төлбөр}}$$

$$ж) \text{ Эргэлтийн хөрөнгийн хувийн жин} = \frac{\text{Нийт эргэлтийн хөрөнгө}}{\text{Нийт хөрөнгө}}$$

$$з) \text{ Цэвэр эргэлтийн хөрөнгийн хувийн жин} = \frac{\text{Цэвэр эргэлтийн хөрөнгө}}{\text{Нийт эргэлтийн хөрөнгө}}$$

$$и) \text{ Төлөгдөх хугацаа хэтэрсэн өр төлбөрийн хувийн жин} = \frac{\text{Хугацаа хэтэрсэн өр төлбөр}}{\text{Нийт өр төлбөр}}$$

### 3.3 Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ

Аж ахуйн нэгж, байгууллагуудын хөрөнгийн эх үүсвэрийн хэмжээ, бүтэц бүрэлдэхүүн, түүний өөрчлөлт зэрэг нь санхүүгийн тогтвортой байдлыг харуулах үндсэн үзүүлэлт болдог. Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээг дараах үзүүлэлтүүдийн дагуу хийнэ. Үүнд:

$$3.3.1 \text{ Бие даах чадварын коэффициент} = \frac{\text{Эздийн өмч}}{\text{Нийт хөрөнгө}}$$

\*Энэ нь гадны эх үүсвэрээс хараат бусаар, өөрийн санхүүжилтээр бие дааж үйл ажиллагаа явуулах чадварыг харуулдаг.

$$3.3.2 \text{ Санхүүгийн хамаарлын коэффициент} = \frac{\text{Нийт хөрөнгө}}{\text{Эздийн өмч}}$$

$$3.3.3 \text{ Зохицуулалтын коэффициент} = \frac{\text{Өөрийн эргэлтийн хөрөнгө}}{\text{Эздийн өмч}}$$

\*Өөрийн эргэлтийн хөрөнгө = Эздийн өмч + Урт хугацаат өр төлбөр -  
- Үндсэн хөрөнгө ба хөрөнгө оруулалт, ББХ

$$3.3.4 \text{ Өр төлбөрийн хувийн жин} = \frac{\text{Нийт өр төлбөр}}{\text{Нийт хөрөнгө}}$$

\*Энэ нь тухайн компанийн нийт хөрөнгийн ямар хэсгийг гадны хөрөнгөөр санхүүжүүлж байгааг харуулна.

$$3.3.5 \text{ Урт хугацаат зээл болон эздийн өмчийн харьцаа} = \frac{\text{Урт хугацаат зээл}}{\text{Эздийн өмч}}$$

$$3.3.6 \text{ Өр төлбөр ба эздийн өмчийн харьцаа} = \frac{\text{Нийт өр төлбөр}}{\text{Эздийн өмч}}$$

3.3.7. Төлбөрийн хэтийн боломжийн үзүүлэлтүүд:

$$\text{а) Хүү төлөх чадвар} = \frac{\text{Хүү + ТТӨА}}{\text{Хүүгийн зардал}}$$

\*ТТӨА - Татварын төлөхийн өмнөх ашиг

$$\text{б) Хүү ба үндсэн өрийг төлөх чадвар} = \frac{\text{Хүү + ТТӨА + Элэгдлийн зардал}}{\text{Хүүгийн зардал - Үндсэн зээлийн өр}}$$

3.3.8. Эргэлтийн хөрөнгө (Бараа материалын нөөц)-ийн санхүүжилтийн тогтвортой байдлын 3 зэрэглэл байна. Үүнд:

- а) МНЗ<ӨЭК-Санхүүгийн үнэмлэхүй тогтвортой байдал
- б) ӨЭК<МНЗ<НХЭҮ-Санхүүгийн тогтворжилт хэвийн
- в) МНЗ>НХЭҮ-Санхүүгийн тогтвортой бус байдал  
 МНЗ-Материаллаг нөөц ба зардал  
 ӨЭК-Өөрийн эргэлтийн капитал  
 НХЭҮ-нөөцийн хэвийн эх үүсвэр  
 НХЭҮ=ӨЭК+материаллаг нөөцөд зориулж авсан зээл, өр төлбөр

3.3.9. Санхүүгийн тогтвортой байдлыг илэрхийлэгч үзүүлэлтүүдийн байвал зохих онолын утгыг дараах 3 түвшинд хувааж үзнэ. Үүнд:

- а) Хангалттай,
- б) Дундаж,
- в) Муу(Сул)

Үзүүлэлт	А түвшин	Б түвшин	В түвшин
Бие даалтын коэффициент	0,5>0	0.03-0.5	0.3<0
Өрийн харьцаа (эх үүсвэрийн квот)	<1	1-1.5	>1

### 3.4 Хөрөнгийн ашиглалтын шинжилгээ

3.4.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн өсөлтийн зохистой харьцаа.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн өсөлтийн харьцаа нь  $T_a > T_b > T_k > 100\%$  байвал зохимжтой байдаг. (Энэ хамаарал алдагдсан тохиолдолд түүний үүссэн нөхцөл шалтгааныг зөв тодруулж үнэлэлт, дүгнэлт өгөх шаардлагатай)

- $T_a$ -Ашгийн өсөлт
- $T_b$ -Үйлдвэрлэлт борлуулалтын өсөлт
- $T_k$ -Үйлдвэрлэлийн чадавхи, хүчин чадлын өсөлт

Эдийн засгийн өсөлтийн тогтворжилт нь байгууллагын үйл ажиллагааны идэвхжилтийг тодорхойлогч хэмжүүрийн нэг юм.

$$\text{Эдийн засгийн өсөлтийн тогтворжилт} = \frac{\text{Тайлант оны цэвэр ашиг} - \text{Ноогдол ашиг}}{\text{Өөрийн капитал}}$$

3.4.2 Эргэцийн шинжилгээ

Эргэц нь эргэлтийн хөрөнгийн нэг хэлбэрээс нөгөөд шилжих хөдөлгөөнийг илэрхийлдэг. Эргэц түргэсэхийн хэрээр үйлдвэрлэлийн үр ашиг нэмэгддэг. Эргэцийн шинжилгээг дараах үзүүлэлтийн дагуу хийнэ. Үүнд:

$$\text{а) Авлагын эргэц (удаа)} = \frac{\text{Зээлээрх борлуулалтын орлого}}{\text{Дансны авлагын дундаж үлдэгдэл}}$$

$$\text{б) Авлагын эргэц (өдөр)} = \frac{360 \text{ хоног}}{\text{Авлагын эргэц (удаа)}}$$



$$в) \text{ Бараа материалын эргэц (удаа)} = \frac{\text{Борлуулсан бүтээгдэхүүний өртөг (ББӨ)}}{\text{Бараа материалын дундаж үлдэгдэл}}$$

$$г) \text{ Бараа материалын эргэц (өдөр)} = \frac{360 \text{ хоног}}{\text{БМ эргэц (удаа)}}$$

$$д) \text{ Эргэлтийн хөрөнгийн эргэц (удаа)} = \frac{\text{Борлуулалтын орлого (цэвэр)}}{\text{Эргэлтийн хөрөнгийн дундаж үлдэгдэл}}$$

$$е) \text{ Эргэлтийн хөрөнгийн эргэц (өдөр)} = \frac{360 \text{ хоног}}{\text{Эргэлтийн хөрөнгийн эргэц (удаа)}}$$

\*Эргэлтийн хөрөнгийн эргэц түргэсэхийн хэрээр борлуулалтын орлого нэмэгдэх тул энэ нь гүйлгээнд хөрөнгийг нэмж оруулсантай адил нөлөөтэй, харин эргэц удааширвал оруулсан хөрөнгө гүйлгээгүй /түжигдмэл/ болж эргэлтээс гарсантай адилт утгатай юм. Иймээс эргэцийн өөрчлөлтөөс хамаарч хэмнэгдсэн /эсвэл нэмж шаардагдах/ хөрөнгийн хэмжээг дараах томъёогоор тооцно. Үүнд:

$$DX = (t_1 - t_0) * ДГ$$

$T_1$   $T_0$ . Суурь ба тайлант үеийн эргэцийн хугацаа  
 ДГ - тайлант үеийн нэг өдрийн дундаж гүйлгээ буюу БОц:360

$$ё) \text{ Нийт хөрөнгийн эргэц} = \frac{\text{Борлуулалтын орлого (цэвэр)}}{\text{Нийт хөрөнгийн дундаж үлдэгдэл}}$$

$$ж) \text{ Өглөгийн эргэц (удаа)} = \frac{\text{Зээлээрх худалдан авалтын өглөг}}{\text{Дансны өглөгийн дундаж үлдэгдэл}}$$

$$з) \text{ Өглөгийн эргэц (өдөр)} = \frac{360 \text{ хоног}}{\text{Өглөгийн эргэц ( удаа )}}$$

$$и) \text{ Үйлдвэрлэлийн циклийн хугацаа} = \text{Авлагын эргэц (өдөр)} + \text{+Бараа материалын эргэц ( өдөр )}$$

$$й) \text{ Санхүүгийн циклийн хугацаа} = \text{Авлагын эргэц (өдөр)} + \text{+Бараа материалын эргэц (өдөр)} - \text{- Өглөгийн эргэц ( өдөр )}$$

### 3.4.3 Бүтээмжийн шинжилгээ

Хөдөлмөрийн нөөц түүнтэй холбогдсон зардал нь капитал зарцуулалтын нэг хэсэг юм. Түүний ашиглалтыг үнэлэх зорилгоор хөдөлмөрийн бүтээмжийн үзүүлэлтийг дараах хувилбаруудаар тооцно. Үүнд:

а) Уламжлалт аргаар буюу үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн эсвэл, борлуулалтын орлогоор:

$$\text{Хөдөлмөрийн бүтээмж} = \frac{\text{Борлуулалтын орлого/Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн}}{\text{Ажиллагсадын тоо}}$$

б) Шинээр бүтээгдсэн нэмэгдсэн өртгөөр:

$$\frac{\text{Нэмэгдсэн өртөг}}{\text{Хөд.бүтээмж}} = \frac{\text{Нэмэгдсэн өртөг}}{\text{Ажилчдын тоо}} : \frac{\text{Хөд.зардал}}{\text{Ажилчдын тоо}} = \frac{\text{Хөд.бүтээмж}}{\text{Хөд.дундаж зардал}}$$

#### 3.4.4 Үндсэн хөрөнгийн ашиглалтын шинжилгээ

Харьцангуй эргэлт удаантай хөрөнгүүд болон өөрийн болон зээлийн капиталын нэгжид ногдох орлогын хэмжээг ачаалалт гэнэ. Энэ нь үйлдвэрлэлд оруулсан нийт хөрөнгө, өөрийн ба гаднын капиталын ашиглалтын түвшин буюу 1 төгрөг тутмаас тайлангийн хугацаанд олсон орлогын хэмжээг илэрхийлнэ. Хөрөнгө капиталын бүрэлдэхүүн хэсгээр ачааллын үзүүлэлтийг тооцоолж үнэлэлт өгдөг. Ингэхдээ нийт хөрөнгө, УГХ, ӨК, БК зэргийг жилийн дундаж үлдэгдэлээр нь, тэдгээрт хамаарах орлогыг зөв харгалзуулж авах нь чухал байдаг.

- а) Нийт хөрөнгийн ачаалал=борлуулалтын орлого: Нийт хөрөнгө
- б) Удаан гүйлгээтэй хөрөнгийн ачаалал=Борлуулалтын орлого:УГХ
- в) Өөрийн капиталын ачаалалт=Борлуулалтын орлого:өөрийн капитал
- г) Байнгын капитал=Борлуулалтын орлого:Байнгын капитал
- д) Үндсэн хөрөнгийн нийт дүнд үйлдвэрлэлийн зориулалттай үндсэн хөрөнгийн эзлэх хувийн жин

$$\frac{\text{Үйлдвэрлэлийн зориулалттай үндсэн хөрөнгө}}{\text{Нийт үндсэн хөрөнгийн өртөг}}$$

е) Үндсэн хөрөнгийн элэгдлийн коэффициент

$$\frac{\text{Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл}}{\text{Үндсэн хөрөнгийн анхны өртөг}}$$

ё) Үндсэн хөрөнгийн шинэчлэлтийн коэффициент

$$\frac{\text{Тайлант хугацаанд шинээр ашиглалтанд орсон үндсэн хөрөнгийн анхны өртөг}}{\text{Тайлант хугацааны эцэст байсан үндсэн хөрөнгийн анхны өртөг}}$$

ж) Үндсэн хөрөнгийн хасагдалтын коэффициент

$$\frac{\text{Тайлант хугацаанд ашиглалтаас хасагдсан үндсэн хөрөнгийн анхны өртөг}}{\text{Тайлант хугацааны эцэст байсан үндсэн хөрөнгийн анхны өртөг}}$$

-----  
Тайлант хугацааны эхэнд байсан үндсэн хөрөнгийн  
анхны өртөг

### 3.5 Орлого, үр дүнгийн шинжилгээ

- 3.5.1 Компаний борлуулалтын орлогын бүрэлдэхүүн (хувийн жин), тэдгээрийн хэлбэлзлэлийг өмнөх он, төлөвлөгөөтэй нь зэрэгцүүлэн судалж, орлогын хичнээн хувь нь ямар эх үүсвэрээс бий болсон байдалд дүгнэлт өгнө.
- 3.5.2 Компаний орлогын өсөлтөнд нөлөөлсөн хүчин зүйл (бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо хэмжээ, бүрэлдэхүүн, худалдах үнэ, валютын ханшны өөрчлөлт, борлуулалтын буцаалт, үнэ хямдруулалт гэх мэт) -ийн нөлөөллийг тулгуур үетэй нь зэрэгцүүлэн тооцоолж дүгнэлт өгнө.
- 3.5.3 Компаний үйлдвэрлэлийн болон удирдлага үйлчилгээний нийт зардал, үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгийн харьцангуй хэлбэлзэл, зардлын хуваарилалт, нэгжийн өртөгийн тооцоог батлагдсан төсөвтэй нь зэрэгцүүлэн дүгнэлт гаргана.
- 3.5.4 Борлуулалтын болон татварын өмнөх ашигт нөлөөлсөн хүчин зүйл (борлуулалтын тоо хэмжээ, худалдсан үнэ, борлуулалтын өртөг, үйл ажиллагааны зардал гэх мэт)-ийн нөлөөллийг тооцоолж үнэлэлт өгөхийн хамт ашгийн өсөлтийг хангах асуудлаар санал боловсруулна.

### 3.6 Ашигт ажиллагааны шинжилгээ

Бизнесийн эцсийн зорилго нь ашиг олох явдал бөгөөд оруулсан хөрөнгийг илүү үр бүтээлтэй ашиглаж, орлогоороо зардлаа нөхөөд ашигтай ажилласан нөхцөлд үйл ажиллагаагаа өргөтгөх боломжтой болно. Ашигт ажиллагааны шинжилгээ нь эдийн засгийн үр ашгийн нэгдсэн үзүүлэлт бөгөөд оруулсан хөрөнгийн нэгж тутмаас олсон ашгийн хэмжээг мөнгөөр илэрхийлдэг чухал үзүүлэлт юм. Ашигт ажиллагааны шинжилгээг дараахь үзүүлэлтүүдийн дагуу хийж, өнгөрсөн болон төлөвлөгөөтэй нь зэрэгцүүлэн дүгнэлт өгнө. Үүнд:

$$3.6.1 \text{ Борлуулалтын ашигт ажиллагаа } /\% \text{-иар/} = \frac{\text{Үйл ажиллагааны цэвэр ашиг}}{\text{Борлуулалтын орлого(цэвэр)}} * 100$$

$$3.6.2 \text{ Хөрөнгийн ашигт ажиллагаа (өгөөж)} = \frac{\text{Хүү ба татварын өмнөх цэвэр ашиг}}{\text{Нийт хөрөнгө}} * 100$$

$$3.6.3 \text{ Эздийн өмчийн ашигт ажиллагаа} = \frac{\text{Тайлант үеийн цэвэр ашиг}}{\text{Эздийн өмч}} * 100$$

### 3.7 Зах зээлийн идэвхижилийн шинжилгээ

Зах зээлийн идэвхижилийн шинжилгээг дараахь үзүүлэлтүүдийн дагуу хийнэ. Үүнд:

$$3.7.1 \text{ Зах зээлийн үнэ} = \frac{\text{Нэгж хувьцааны зах зээлийн үнэ}}{\text{ба ашгийн харьцаа}} \frac{\text{Нэгж хувьцаанд ногдох цэвэр ашиг}}$$

\*Тус үзүүлэлт нь тухайн компанийн хувьцааны эрэлтийг харуулдаг гол үзүүлэлт бөгөөд хувьцааны нэгжид ногдох ашгийн төгрөг тутамд хөрөнгө оруулагчид хэдэн төгрөг төлж байгааг харуулдаг.

$$3.7.2 \text{ Зах зээлийн үнэ} = \frac{\text{Нэгж хувьцааны зах зээлийн үнэ}}{\text{ба бүртгэлийн үнийн харьцаа}} \frac{\text{Нэгж хувьцааны бүртгэлийн үнэ}}$$

\*Тус үзүүлэлт нь тухайн үед хувьцааны нэгж тутамд ногдох бодит хөрөнгийн, бүртгэлийн үнээс давуулж төлсөн үнэ буюу хөрөнгө оруулагчдын зүгээс компаний ирээдүйд хэр итгэж байгааг харуулдаг чухал үзүүлэлт юм.

$$3.7.3 \text{ Нэгж хувьцааны бүртгэлийн үнэ} = \frac{\text{Хувьцаа эзэмшигчдын өмч-Давуу эрхтэй хувьцааны үнэ}}{\text{Энгийн хувьцааны тоо}}$$

$$3.7.4 \text{ Ногдол ашгийн олголт} = \frac{\text{Нэгж хувьцааны ногдол ашиг}}{\text{Нэгж хувьцааны цэвэр ашиг}}$$

\*Тус үзүүлэлт нь тухайн компани цэвэр ашгийнхаа хэдэн хувийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийн хэлбэрээр хуваарилж байгааг харуулдаг.

$$3.7.5 \text{ Хувьцаа эзэмшигчдын ашигт ажиллагаа} = \frac{\text{Нэгж хувьцааны ногдол ашиг}}{\text{Нэгж хувьцааны зах зээлийн үнэ}}$$

\*Тус үзүүлэлт нь тухайн компанид оруулсан хөрөнгөнөөс хувьцаа эзэмшигчдийн хүртэж байгаа өгөөжийг харуулдаг.

$$3.7.6 \text{ Хувьцааны нэгжид ногдох ногдол ашиг} = \frac{\text{Цэвэр ашиг - ДЭХ - ХА}}{\text{Гаргасан энгийн хувьцааны тоо}}$$

ДЭХ - давуу эрхтэй хувьцаанд хуваарилсан ногдол ашиг  
ХА - Хуримтлагдсан ашгийг нэмэгдүүлсэн хэсэг

\*Тус үзүүлэлт нь хувьцаа эзэмшигчдэд хуваарилсан ногдол ашгийн хэмжээг харуулдаг. Гэхдээ хөрөнгө оруулагчид хувьцааг худалдан авахдаа гагцхүү ногдол

ашгийн төлөө бус тухайн компаний үр ашигтай ажиллагаа, ирээдүйн найдвартай байдлыг чухалчилдаг. Иймээс хувьцааны нэгжид ногдох ашиг өсөх нь дангаараа үнэт цаасны зах зээл дээр тухайн компаний нэгж хувьцааны үнэ өсөх үндсэн шалтгаан болдоггүй.

### 3.8 Мөнгөн урсгалын шинжилгээ

Байгууллагын санхүү төлбөрийн чадварын өнөөгийн байдал, хэтийн төлөвийг тодорхойлж үнэлэлт өгөхөд мөнгөн урсгалын шинжилгээ чухал мэдээллийг багтаадаг. Мөнгөн урсгалын шинжилгээг дараах үзүүлэлтүүдийн дагуу хийнэ. Үүнд:

$$3.8.1 \text{ Цэвэр эргэлтийн хөрөнгө ба борлуулалтын харьцаа} = \frac{\text{Цэвэр эргэлтийн хөрөнгө}}{\text{Борлуулалтын орлого(цэвэр)}}$$

$$3.8.2 \text{ Цэвэр эргэлтийн хөрөнгө ба нийт хөрөнгийн харьцаа} = \frac{\text{Цэвэр эргэлтийн хөрөнгө}}{\text{Нийт хөрөнгө}}$$

$$3.8.3 \text{ Мөнгөн орлого ба борлуулалтын харьцаа} = \frac{\text{Үйл ажиллагааны мөнгөн орлогын гүйлгээ}}{\text{Борлуулалтын орлого (цэвэр)}}$$

$$3.8.4 \text{ Мөнгөн орлого ба хөрөнгийн харьцаа} = \frac{\text{Үйл ажиллагааны мөнгөн орлогын гүйлгээ}}{\text{Нийт хөрөнгө}}$$

$$3.8.5 \text{ Мөнгөн зарлага ба борлуулалтын харьцаа} = \frac{\text{Үйл ажиллагааны мөнгөн зарлага}}{\text{Борлуулалтын өртөг}}$$